



## БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

### Гүйцэтгэлийн аудитын тайлан

Улсын төсвийн хөрөнгө оруулалтын 2018 оны төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр нөлөө



**УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТУХАЙН ЖИЛД ХҮРЭХ ЗОРИЛТОТ ТҮВШИН 82 ХУВЬТАЙ БАЙНА.**



## АГУУЛГА

<p><b>Тайланг бэлтгэсэн:</b></p> <p><b>Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газар</b></p> <p><b>Дарга бөгөөд тэргүүлэх аудитор</b> М.Хуанган</p> <p><b>Аудитын менежер</b> Х.Женисбек</p> <p><b>Аудитор</b> Б.Үүрийнтуяа</p> <p><b>Гэрээт аудитор</b> К.Риза</p> <p><b>2019 оны 4 дүгээр сар</b></p> <p>Аудитын тайланг ҮАГГазрын <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> вэб сайтаас үзнэ үү.</p> <p>Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 89838414, 94156768 дугаарын утсаар харилцана уу.</p> <p><b>ХАЯГ:</b> Аймгийн ЗДТГазрын байр, 108, 107 тоот өрөө</p>	<p>Товчилсон үгийн тайлбар .....4</p> <p>Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй.....5-6</p> <p>Оршил .....7</p> <p><b>Бүлэг 1. Хөрөнгө оруулалтын төлөвлөлт үндэслэлтэй хийгдсэн байна.</b></p> <p><b>А.1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтыг нэгдсэн бодлогод уялдуулах арга хэмжээ авч ажиллажээ.</b></p> <ul style="list-style-type: none"> <li>• А.1.1. Жагсаалтад батлагдсан төсөл, арга хэмжээ нь улсын төсвийн хөрөнгө оруулалтын нэгдсэн хөтөлбөр, аймгийн 2018 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөө болон салбарын бодлогод нийцсэн байна. 8</li> <li>• А.1.2. Жагсаалтад батлагдсан төсөл, арга хэмжээ ТЕЗ-дын саналд үндэслэгдсэн байна. 8</li> </ul> <p><b>А.2. Хууль журамд заасан шаардлагыг хангасан төсөл арга хэмжээг төлөвлөж, батлуулсан байна.</b></p> <ul style="list-style-type: none"> <li>• А.2.1. Хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний жагсаалтад нэр, хэрэгжих хугацаа, байршил тодорхой төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр батлуулсан байна. 8-9</li> <li>• А.2.2. Шинээр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний ТЭЗҮ, зураг төсвийг жагсаалт батлуулахаас өмнө боловсруулсан байна. 8-9</li> <li>• А.2.3. Шинээр хэрэгжүүлэх барилга, байгууламжийн газрын зөвшөөрөл, техникийн нөхцөл олгогдсон байна. 8-9</li> <li>• А.2.4. Шинээр хэрэгжих 4 төсөл арга хэмжээний зураг, төсөвт дахин магадлал хийлгэж, баталгаажуулсан байна. 8-9</li> <li>• А.2.5. Их засвар, тоног төхөөрөмжийг хэрэгцээнд тулгуурлан төлөвлөсөн байна. 9-10</li> <li>• А.2.6. Хөрөнгө оруулалтын шинж чанартай бус төсөл арга хэмжээ төлөвлөгдөөгүй байна. 10</li> </ul> <p style="text-align: center;"><b>Дүгнэлт ..... 11</b></p> <p><b>Бүлэг 2. Зарим төсөл арга хэмжээ гэрээнд заасан хугацаандаа хэрэгжээгүй байна.</b></p> <p><b>Б.1. Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажиллагаа холбогдох хууль журмын дагуу зохион байгуулагдсан байна.</b></p> <ul style="list-style-type: none"> <li>• Б.1.1. Эрх шилжүүлэн хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээг хэрэгжүүлэх боломжтой хугацаанд шилжүүлжээ. 12-13</li> <li>• Б.1.2. Үнэлгээний хороог хуулийн дагуу байгуулсан байна. 13</li> <li>• Б.1.3.Тендерийн баримт бичгийг хууль журмын дагуу боловсруулсан байна. 14-15</li> <li>• Б.1.4. Сонгон шалгаруулалтыг ил тод, нээлттэй өрсөлдөх боломжоор хангаж зохион байгуулсан байна. 14-15</li> <li>• Б.1.5.ТЕЗ худалдан авах ажиллагааны тайланг хугацаанд нь тайлагнасан байна. 15</li> </ul> <p><b>Б.2. Зарим гүйцэтгэгч гэрээний үүргээ хугацаанд нь биелүүлээгүй байна.</b></p> <ul style="list-style-type: none"> <li>• Б.2.1 Зарим төсөл арга хэмжээ гэрээнд заасан хугацаандаа хэрэгжээгүй байна. 15-17</li> <li>• Б.2.2. Захиалагч зохиогч, мэргэжлийн байгууллагын хяналтаар илэрсэн зөрчлийг тухай бүрд нь арлгах арга хэмжээг авч ажилласан байна. 17</li> <li>• Б.2.3. Гүйцэтгэгч төсөл, арга хэмжээний санхүүжилтийг зориулалтын дагуу зарцуулсан байна. 17-19</li> </ul> <p><b>Б.3. Зарим төсөл арга хэмжээний гүйцэтгэгч компаниуд гэрээгээр хүлээсэн үүргээ хангалтгүй хэрэгжүүлсэн байна.</b></p>
--	--



- Б.3.1. Төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд захиалагчийн тавих үе шатны хяналтыг барилгын үе шат бүрээр хяналт тавьж баталгаажуулсан байна. 19
- Б.3.2. Төсөл арга хэмжээний санхүүжилтийг бодит гүйцэтгэлд үндэслэн журамд заасан хугацаанд олгосон байна. 20
- Б.3.3. Хөрөнгө оруулалтын хэрэгжилтийн тайланг хугацаанд хүргүүлсэн байна. 20
- Б.3.4. Гэрээний үүргээ биелүүлээгүй гүйцэтгэгчид хариуцлага тооцоогүй байна. 20-21

**Б.4. Хөрөнгө оруулалтын үйл явцад тавих Засгийн газрын болон ТЕЗ-дын дотоод хяналт үр нөлөөтэй байна.**

- Б.4.1. Санхүү төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас тавих хяналт үр дүнтэй байна. 21
- Б.4.2. Хөрөнгө оруулалтын хэрэгжилтэд тавих ТЕЗ-ийн дотоод хяналтыг зохих түвшинд тавьж ажилласан байна. 21

**Дүгнэлт** ..... 22

**Бүлэг 3. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын тухайн жилд хүрэх зорилтот түвшин 82 хувьтай байна.**

**В.1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын тухайн жилд хүрэх зорилтот түвшин 82 хувьтай байна.**

- В.3.1. 2018 онд ашиглалтад орсон төсөл, арга хэмжээ бүрэн хүчин чадлаар ашиглагдаж байна. 23-28

**В.2. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээнүүд зохих үр нөлөөгөө өгчээ.**

- В.2.1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн төсөл арга хэмжээ зохих үр нөлөөгөө өгсөн байна. 28-29
- В.2.2. Хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний төсөвт өртгийг нэмэгдүүлсэн гэж үзэх үндэслэл байхгүй байна. 28-29
- В.2.3. Өмнөх аудитаар өгсөн зөвлөмж өгөгдөөгүй байна. 28-29

**Дүгнэлт** ..... 30

**Зөвлөмж** .....31

**Холбогдох байгууллагын санал** .....32



## Товчилсон үгийн тайлбар

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
МХГ	Мэргэжлийн хяналтын газар
ТЭЗҮ	Техник эдийн засгийн үзүүлэлт
ХХААХҮСайд	Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрлэлийн сайд
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ХХААГ	Хүнс, хөдөө аж ахуйн газар
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ТАХ	Төсөл арга хэмжээ
БСШУЯ	Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам
МХГ	Мэргэжлийн хяналтын газар
БСУГ	Боловсрол соёл урлагийн газар
ХДТ	Хөгжим драмын театр
МСҮТ	Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төв
БСШУС	Боловсрол соёл шинжлэх ухааны сайд
ХХААХҮС	Хүнс хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрлэлийн сайд
ХНХ	Хөдөлмөр, Нийгмийн хамгааллын сайд
БХБС	Барилга, хот байгуулалтын сайд
ГХБХБГ	Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар



## Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй

### Аудитын зорилт

Монгол Улсын Ерөнхий аудитораас баталсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу “Улсын төсвийн хөрөнгө оруулалтын 2018 оны төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр нөлөө”-т гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт гарган, аудитын мөрөөр илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах, хөрөнгө оруулалтын үр ашгийг дээшлүүлэх санал зөвлөмжийг холбогдох байгууллага, албан тушаалтнуудад өгөхөд аудитын зорилт чиглэгдлээ.

### Хамарсан хүрээ

Энэхүү аудитад УИХ, холбогдох яам, аймаг, сумын ИТХурал, Засаг дарга, ЗДТГазраас гаргасан холбогдох шийдвэрүүд, Худалдан авах ажиллагааны нэгжээс зохион байгуулсан ажлын үр дүн, ажлын явцын болон холбогдох санхүүгийн ажлын тайлан, бусад тооцоо судалгаа үйл ажиллагаануудыг хамрууллаа.

### Эрсдэлийн үнэлгээ:

Аудитын төлөвлөлтийн явцад судалсан баримт материал, харилцан ярилцлагад тулгуурлан хийсэн урьдчилсан дүн шинжилгээнд үндэслэн ерөнхий эрсдэлийг “Дунд” гэж үнэлсэн.

### Аудитын арга зүй

Аудитыг гүйцэтгэхэд Төрийн хяналт шалгалтын стандарт, Гүйцэтгэлийн аудитын удирдамж /АДБОУС 3000-3100/, Гүйцэтгэлийн аудитын журам, гүйцэтгэлийн аудитын арга зүйг ашиглан, аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс, Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс, Орон нутгийн өмчийн газрын худалдан авах ажиллагааны холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, санал, асуулга, лавлагаа авах, хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээний хэрэгжилтийг газар дээр нь үзэж танилцан фото зураг, судалгаа авч дүн, шинжилгээ хийх, зэрэг арга зүйг ашигласны зэрэгцээ аудитын хөтөлбөр, горимын дагуу нотлох зүйл цуглуулж, дүгнэлт, зөвлөмж боловсрууллаа.

### Асуудлын талаар товч мэдээлэл:

Тус аймагт Монгол Улсын 2018 оны Төсвийн тухай хуулийн дагуу улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 15432,6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 22 төсөл арга хэмжээг 6751,2 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр баталсан байна.



## Аудитад ашиглах шалгуур үзүүлэлтүүд

Аудитын зорилттой холбоотой дараах хууль тогтоомж, дүрэм, журам, заавар, эрх зүйн актуудыг шалгуур үзүүлэлт болгон ашиглав. Үүнд:

1. Төрийн аудитын тухай хууль
2. Төсвийн тухай хууль
3. Монгол Улсын 2018 оны төсвийн тухай хууль
4. Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
5. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
6. Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 140 дүгээр тогтоолоор батлагдсан “Монгол Улсын 2018-2021 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр”
7. Сангийн сайдын 2016 оны 415 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналын журам”
8. Сангийн сайдын 2017 оны 363 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналын журам”
9. Аймгийн Засаг даргын 2016-2020 оны мөрийн хөтөлбөр
10. Холбогдох бусад хууль тогтоомж, эрхийн акт

Аудитын багийн бүрэлдэхүүн:

Энэхүү гүйцэтгэлийн аудитыг аудитор Б.Үүрийнтуяа, гэрээт аудитор К.Риза нарын бүрэлдэхүүнтэй аудитын баг хуваарийн дагуу төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн байдалд гүйцэтгэлийн аудит хийж, аудитын тайланг бэлтгэв.

Аудитын тайлангийн хавсралт судалгаа мэдээнүүдийг тайланд хавсаргав.



# Бүлэг 1

*Хөрөнгө оруулалтын төлөвлөлт үндэслэлтэй хийгдсэн байна.*

## Оршил

“Улсын төсвийн 2018 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр нөлөө” сэдэвт гүйцэтгэлийн аудитын батлагдсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу Баян-Өлгий аймагт 2018 онд хэрэгжсэн хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээний хэрэгжилтийн байдалд 2019 оны 03 дугаар сарын 11-ний өдрөөс 04 дүгээр сарын 10-ны өдрийг хүртэл хугацаанд гүйцэтгэлийн аудит хийлээ.

Гүйцэтгэлийн аудитад 2018 онд Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлж, Төсвийн ерөнхийлөн захирагчдаас орон нутагт эрх шилжүүлэн хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээг бүрэн хамруулав.

Улсын төсвийн хөрөнгөөр Баян-Өлгий аймагт 2018 онд хэрэгжих 19, он дамжин хэрэгжих 3, нийтдээ 15432,6 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 22 хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг 6751,2 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр 2018 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгаж, холбогдох яамдын Төсвийн ерөнхийлөн захирагчдаас орон нутагт эрх шилжүүлжээ.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар тус аймагт Сагсай сумын Хүүхдийн цэцэрлэг, Дэлүүн сумын 1 дүгээр сургуулийн дотуур байр, Өлгий сумын Бага сургууль, цэцэрлэгийн цогцолбор, Буянт сумын Халуун усны болон Өлгий сумын үерийн хамгаалалтын далан сувгийн барилга, Өлгий сумын 4 дүгээр багийн айл өрхийг цэвэр усны шугамд холбох, 1000, 900 айлын орон сууцны хороолол, ус дамжуулах шугам сүлжээний ажил зэрэг шинээр 7 барилга угсралтын ажил,

Мөн Аймгийн БСУГазрын контор, ХДТеатрын байр, МСҮТөвийн дотуур байр, Өлгий сумын 5 дугаар сургуулийн спорт заал, Нэгдсэн эмнэлгийн сэтгэц наркологи тасаг, Аймгийн Орон нутгийг судлах музей зэрэг 7 барилга объектийн засварын ажил, Аймгийн төвийн гудамжны гэрэлтүүлэг, цахилгаан шугам сүлжээний зураг төсөв, Төрийн үйлчилгээний нэгдсэн цогцолборын зураг төсөв зэрэг 2 зураг төсвийн ажил,

Толбо сумын Зуслангийн авто зам, давааны засварын ажил, Толбо сумын Нарийн голын модон гүүр, Хойд голын модон гүүр, Алтай сумын услалтын систем, Баяннуур сумын ногооны зоорь барих ажил, аймгийн ЗДТГазарт автомашин нийлүүлэх, ХДТ-т хөгжмийн зэмсэг худалдан авах зэрэг нийтдээ 22 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр 2018 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд орж батлагдсан байна.



## ***А.1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтыг нэгдсэн бодлогод уялдуулах арга хэмжээ авч ажиллажээ.***

*А.1.1. Жагсаалтад батлагдсан төсөл, арга хэмжээ нь улсын төсвийн хөрөнгө оруулалтын нэгдсэн хөтөлбөр, аймгийн 2018 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөө болон салбарын бодлогод нийцсэн байна.*

Баян-Өлгий аймагт 2018 онд хэрэгжүүлэхээр төлөвлөгдсөн төсөл, арга хэмжээнүүд нь аймгийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөө болон аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөнд тусгагдсан, салбарын бодлоготой уялдсан байна.

*А.1.2. Жагсаалтад батлагдсан төсөл, арга хэмжээ ТЕЗ-дын саналд үндэслэгдсэн байна.*

Аймгийн ЗДТГазрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсээс 2018 онд аймгийн хэмжээнд шаардлагатай хөрөнгө оруулалтын ажлын төслийг салбарын байгууллагуудаас ирүүлсэн саналыг үндэслэн нэгтгэж, шаардлагатай тооцоо, судалгааны хамт аймгийн Засаг даргаар хянуулан батлуулжээ.

Дээрх хөрөнгө оруулалтын жагсаалтыг харьяа салбарын яам, Сангийн яаманд 2018 оны 8 дугаар сарын 15-нд Төсвийн тухай хуульд заасан хугацаанд хүргүүлсэн байна.

Тус аймагт 2013-2020 онуудад хийгдэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний саналын эрэмбэлсэн жагсаалт, аймгийн Засаг даргын 2016-2020 оны мөрийн хөтөлбөр болон салбарын удирдах байгууллагуудын санал, аймгийн 2018 онд хөрөнгө оруулалт шаардлагатай төсөл арга хэмжээний жагсаалт, төсвийн байгууллага, иргэдийн санал, хөрөнгө оруулалт шаардлагатай объектийн бодит байдалд хийсэн МХГазрын улсын байцаагчийн дүгнэлт зэргийг харгалзан хөрөнгө оруулалт шаардлагатай төсөл, арга хэмжээнүүдээс нэн шаардлагатай төсөл арга хэмжээнүүд 2018 оны Улсын төсвийн хөрөнгө оруулалтын жагсаалтад орж батлагдсан байна.

## ***А.2. Хууль журамд заасан шаардлагыг хангасан төсөл арга хэмжээг төлөвлөж, батлуулсан байна.***

*А.2.1. Хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний жагсаалтад нэр, хэрэгжих хугацаа, байршил тодорхой төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр батлуулсан байна.*

2018 онд хэрэгжсэн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээнүүдийн нэр, хэрэгжих хугацаа, байршил нь тодорхой ба ашиглагч байгууллага нь тодорхойгүй төсөл арга хэмжээ төлөвлөгдөөгүй бөгөөд хэрэгжих явцад төсөл арга хэмжээний нэр, хугацаа, байршилд өөрчлөлт ороогүй байна.

*А.2.2. Шинээр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний ТЭЗҮ, зураг төсвийг жагсаалт батлуулахаас өмнө боловсруулсан байна.*

Захиалагч байгууллагаас 2018 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгагдаж шинээр хэрэгжихээр батлагдсан барилга угсралтын 7



ажил, 7 барилга объектэд хийх их засвар, зам засварын 3 ажил, газар тариалангийн усалгаатай талбай болон ногооны зоорь барих ажлуудад зураг төсвийг болон аймгийн ЗДТГазарт автомашин, ХДТеатрт хөгжмийн зэмсэг нийлүүлэх ажилд үнийн судалгаа, техникийн тодорхойлолтыг урьдчилан бэлтгэж шаардагдах хөрөнгө оруулалтын тооцоог харьяа яаманд хүргүүлсэн байна.

Захиалагчаас боловсруулж, эрх бүхий зураг төсөвчнөөр хийлгэсэн ажлын даалгавар, зохих стандартын шаардлага, норм номативт үндэслэн зориулалтыг бүрэн заасан техникийн тодорхойлолтыг боловсруулан гаргасан байна.

*А.2.3. Шинээр хэрэгжүүлэх барилга, байгууламжийн газрын зөвшөөрөл, техникийн нөхцөл олгогдсон байна.*

2018 онд хэрэгжсэн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээнүүдийн шинээр хэрэгжих 7 барилга угсралтын ажлын газрын зөвшөөрөл болон техникийн нөхцөлийг холбогдох байгууллагуудаас олгосон байна.

Барилгын тухай хуулийн 12 дугаар зүйлд заасан барилгын зураг төсөлд тавих шаардлагын дагуу газрын зөвшөөрөл, геологийн шинжилгээ, эрчим хүчний болон усан хангамж, ариутгах татуурга, байгаль орчны байгууллага, галын аюулаас урьдчилан хамгаалах байгууллагын зөвшөөрөл, техникийн нөхцөлүүд бүрэн олгогдсон байна.

*А.2.4. Шинээр хэрэгжих 4 төсөл арга хэмжээний зураг, төсөвт дахин магадлал хийлгэж, баталгаажуулсан байна.*

Дэлүүн сумын 1 дүгээр сургуулийн дотуур байрны барилга, Өлгий сумын үерийн хамгаалалтын далан сувгийн барилга, Сагсай сумын Хүүхдийн цэцэрлэгийн барилга, Бага сургууль, цэцэрлэгийн цогцолборын барилга, Өлгий сумын үерийн хамгаалалтын далан сувгийн барилга зэрэг төсөл арга хэмжээнүүдийн зураг төсөвт Барилгын хөгжлийн төвөөр магадлал хийлгэж баталгаажуулсан байна.

Дэлүүн сумын 1 дүгээр сургуулийн дотуур байрны халаалтын эх үүсвэрийг нэгдсэн халаалтын шугамд холбохоор зураг төсөв хийгдсэнийг захиалагчийн хүсэлтээр нам даралтын зуухаар халаахаар дахин магадлал хийлгэх үед зураг төсөвт өөрчлөлт оруулсан байна.

*А.2.5. Их засвар, тоног төхөөрөмжийг хэрэгцээнд тулгуурлан төлөвлөсөн байна.*

2018 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгагдсан 7 барилга объектэд хийх засварын ажил болон аймгийн ЗДТГазарт автомашин нийлүүлэх ажлыг холбогдох байгууллагуудын дүгнэлт, хэрэгцээ шаардлагад тулгуурлан төлөвлөжээ.

Тухайлбал: МСҮТөвийн дотуур байр, Өлгий сумын 5 дугаар сургуулийн спорт заал, Нэгдсэн эмнэлгийн сэтгэц наркологийн тасаг, Аймгийн Орон нутгийг судлах музей зэрэг байгууллагуудад засвар хийлгэх шаардлагатай талаар МХГазрын холбогдох байцаагчдаас дүгнэлт гаргуулсан, Аймгийн БСУГазар, ХДТеатр, МСҮТөв, Өлгий сумын 5 дугаар сургууль, Нэгдсэн эмнэлэг, Аймгийн Орон нутгийг



судлах музей, Толбо сумын ЗДТГазар зэрэг байгууллагуудаас засвар хийлгэх талаар хүсэлт ирүүлсэн байна.

Аймгийн ЗДТГазраас хэлтсийн дарга, мэргэжилтнүүд хөдөө орон нутагт албан ажилд ашиглах зорилгоор автомашин шаардлагатай байгаа талаар Засгийн газрын хэрэг эрхлэх газарт хүсэлт гаргасан байна.

*А.2.6. Хөрөнгө оруулалтын шинж чанартай бус төсөл арга хэмжээ төлөвлөгдөөгүй байна.*

2018 оны Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр төлөвлөсөн хөрөнгө оруулалтын ажлын төлөвлөгөөнд хөрөнгө оруулалтын шинж чанартай бус төсөл арга хэмжээ төлөвлөгдөөгүй байна.



## ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлт хийж байна. Үүнд:

### **Бүлэг 1. Хөрөнгө оруулалтын төлөвлөлт үндэслэлтэй хийгдсэн байна.**

#### ***А.1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтыг нэгдсэн бодлогод уялдуулах арга хэмжээ авч ажиллажээ.***

- А.1.1. Жагсаалтад батлагдсан төсөл, арга хэмжээ нь улсын төсвийн хөрөнгө оруулалтын нэгдсэн хөтөлбөр, аймгийн 2018 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөө болон салбарын бодлогод нийцсэн байна.
- А.1.2. Жагсаалтад батлагдсан төсөл, арга хэмжээ ТЭЗ-дын саналд үндэслэгдсэн байна.

#### ***А.2. Хууль журамд заасан шаардлагыг хангасан төсөл арга хэмжээг төлөвлөж, батлуулсан байна.***

- А.2.1. Хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний жагсаалтад нэр, хэрэгжих хугацаа, байршил тодорхой төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр батлуулсан байна.
- А.2.2. Шинээр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний ТЭЗҮ, зураг төсвийг жагсаалт батлуулахаас өмнө боловсруулсан байна.
- А.2.3. Шинээр хэрэгжүүлэх барилга, байгууламжийн газрын зөвшөөрөл, техникийн нөхцөл олгогдсон байна.
- А.2.4. Шинээр хэрэгжих 4 төсөл арга хэмжээний зураг, төсөвт дахин магадлал хийлгэж, баталгаажуулсан байна.
- А.2.5. Их засвар, тоног төхөөрөмжийг хэрэгцээнд тулгуурлан төлөвлөсөн байна.
- А.2.6. Хөрөнгө оруулалтын шинж чанартай бус төсөл арга хэмжээ төлөвлөгдөөгүй байна.



## Бүлэг 2

**Зарим төсөл арга хэмжээ гэрээнд заасан  
хугацаандаа хэрэгжээгүй байна.**

### **Б.1. Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажиллагаа холбогдох хууль журмын дагуу зохион байгуулагдсан байна.**

Б.1.1. Эрх шилжүүлэн хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээг хэрэгжүүлэх  
боломжтой хугацаанд шилжүүлжээ.

-БСШУС-ын сайдын 2018 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн 1а/149 тоот тушаалаар Өлгий сумын Бага сургууль, цэцэрлэгийн цогцолборын барилга, 01 дүгээр сарын 05-ны өдрийн А/008 тоот тушаалаар Сагсай сумын Хүүхдийн цэцэрлэгийн байрны барилга, Дэлүүн сумын 1 дүгээр сургуулийн дотуур байрны барилга барих ажлын, 04 дүгээр сарын 27-ны өдрийн А/230 тоот тушаалаар “Аймгийн БСУГазрын конторын засвар”, “Аймгийн ХДТеатрын байрны засвар”, “Өлгий сумын Хүүхдийн 1, 7 дугаар цэцэрлэгүүдийн байрны засвар”-ын ажлуудын,

Мөн 05 дугаар сарын 7-ны өдрийн А/246 тоот тушаалаар ХДТеатрт хөгжмийн зэмсэг худалдан авах ажлын, 07 дугаар сарын 2-ны өдрийн А/411 тоот тушаалаар “Аймгийн Орон нутгийн судлах музейн засвар”-ын ажлын, 09 дүгээр сарын 20-ны өдрийн А/591 тоот тушаалаар Өлгий сумын 5 дугаар сургуулийн барилгын засварын ажил, бүгд 10 ажлын захиалагчийн эрхийг аймгийн Засаг даргад тус тус шилжүүлсэн байна.

-Барилга, хот байгуулалтын сайдын 2017 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 218 тоот тушаалаар Буянт сумын Халуун усны барилга барих болон Өлгий сумын 4 дүгээр багийн айл өрхийг цэвэр усны шугамд холбох ажлын захиалагчийн эрхийг, 2018 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн 31 тоот тушаалаар Өлгий сумын үерийн хамгаалалтын далан сувгийн барилгын эхний ээлжийн ажил, 08 дугаар сарын 16-ны өдрийн 142 тоот тушаалаар Аймгийн төвийн гудамжны гэрэлтүүлэг, цахилгаан шугам сүлжээний зураг төсөв, Төрийн үйлчилгээний нэгдсэн цогцолборын зураг төсөв, 1000, 900 айлын орон сууцны хороолол, ус дамжуулах шугам сүлжээний ажил зэрэг 6 ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах, гэрээ байгуулах эрхийг Аймгийн Засаг даргад тус тус шилжүүлжээ.

-Хөдөлмөр, Нийгмийн хамгааллын сайдын 2018 оны 05 дугаар сарын 23-ны өдрийн А/118 тоот тушаалаар МСҮТөвийн дотуур байрны засварын ажлын захиалагчийн эрхийг Аймгийн Засаг даргад шилжүүлсэн байна.

-Засгийн газрын хэрэг эрхлэх газрын даргын 2018 оны 4 дүгээр сарын 4-ний өдрийн 98 тоот тушаалаар аймгийн ЗДТГазарт автомашин нийлүүлэх ажлын захиалагчийн эрхийг Аймгийн Засаг даргад шилжүүлсэн байна.



-Зам тээврийн хөгжлийн сайдын 2018 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн 09 тоот тушаалаар Толбо сумын Зуслангийн авто зам, давааны засварын ажил, 05 дугаар сарын 15-ны өдрийн 104/А/165 тоот тушаалаар Толбо сумын Нарийн голын модон гүүр, Хойд голын модон гүүр барих 3 ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах, гэрээ байгуулах эрхийг Аймгийн Засаг даргад шилжүүлжээ.

-Эрүүл мэндийн сайдын 2018 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн А/98 тоот тушаалаар “Аймгийн Нэгдсэн эмнэлгийн наркологийн тасгийн засварын ажил”-ын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах, гэрээ байгуулах эрхийг аймгийн ЭМГазрын даргад шилжүүлсэн байна.

-ХХААХҮ-ийн сайдын 2018 оны 1 дүгээр сарын 11-ний өдрийн А/06/06 тоот тушаалаар “Алтай сумын услалтын систем”, “Баяннуур сумын ногооны зорь барих” ажлуудын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах, гэрээ байгуулах эрхийг Аймгийн Засаг даргад шилжүүлжээ.

Өлгий сумын Хүүхдийн 1, 7 дугаар цэцэрлэгийн байрыг шинээр барих ажлыг дараа оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд оруулахаар болсон тул захиалагчийн зүгээс БСШУС-ын яаманд санхүүжилтийг өөр ажилд шилжүүлэхээр хүсэлт тавьж, улмаар 2018 оны эрх шилжүүлсэн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнөөс хасаж, Өлгий сумын 5 дугаар сургуулийн засварын ажилд шаардлагыг харгалзан шилжүүлсэн байна.

ТЕЗ-аас эрх шилжүүлсэн хугацааны хувьд 1000, 900 айлын орон сууцны хороолол, ус дамжуулах шугам сүлжээний ажил, Өлгий сумын 5 дугаар сургуулийн барилгын засварын ажлуудыг 9 дүгээр сарын 20-нд шилжүүлсэн ба бусад ажлуудыг ажил гүйцэтгэх боломжтой хугацаанд шилжүүлсэн байна.

Сангийн сайдын 2016 оны 415 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналтын журам”-д заасны дагуу эрх шилжсэн төсөл арга хэмжээнүүдийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлыг ТЕЗ-даас эрх шилжүүлсэн шийдвэрийг үндэслэн 2018 онд хэрэгжих төсөл арга хэмжээнүүдийг Орон нутгийн өмчийн газар худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд 3 дугаар сараас 10 дугаар сарын хооронд явуулахаар төлөвлөсөн байна.

#### *Б.1.2. ТЕЗ үнэлгээний хороог хуулийн дагуу байгуулсан байна.*

Төсөл арга хэмжээнүүдийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахдаа ажил тус бүр дээр үнэлгээний хороо байгуулан ажиллуулсан байна.

Үнэлгээний хороог Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.3 дахь зүйлд заасан шаардлагыг хангахуйц худалдан авах ажиллагааны чиглэлээр мэргэшсэн, АЗ сертификаттай, худалдан авах ажиллагааны салбарын мэргэжилтнүүд болон аймгийн ЗДТГ-ын ажилтнуудын төлөөлөл, иргэний төлөөллийг оролцуулан 5 хүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулж ажилласан байна.



*Б.1.3.Тендерийн баримт бичгийг хууль журмын дагуу боловсруулсан байна.*

Захиалагчаас тендерийн бичиг баримтыг тендерийн урилга тараахаас өмнө боловсруулан тендерт оролцох хүсэлтэй иргэн, аж ахуйн нэгжүүдэд урилгын хамт тараасан байна.

Тендерийн баримт бичгийг худалдан авах ажлын төрөл болон худалдан авах ажиллагааны хэлбэртэй холбоотойгоор Сангийн яамнаас баталсан тендерийн жишиг баримт бичиг, гэрээний маягт болон тендер шалгаруулалтад холбогдох бусад журам аргачлалын дагуу бэлтгэж боловсруулж, тендерийн бичиг баримтыг цаасаар болон цахим хэлбэрээр бүрдүүлсэн байна. Тайлант онд тендерийн бичиг баримтын үнээс нийтдээ 1,9 сая төгрөг оруулсан байна.

*Б.1.4. Сонгон шалгаруулалтыг ил тод, нээлттэй өрсөлдөх боломжоор хангаж зохион байгуулсан байна.*

Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлыг ил тод, нээлттэй өрсөлдөх боломжоор хангах үүднээс сонгон шалгаруулалтыг цахим хэлбэрээр явуулсан байна.

2018 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөө болон тендер шалгаруулалтын тухай дэлгэрэнгүй мэдээллийг Засгийн газрын ХААУХШМ-ийн системд оруулан “Үнэн” сонинд нийтэлж, аймгийн “Tender.gov.mn”, “bayan-ulgii.gov.mn” сайтуудаар нийтэд зарлан мэдээлж, сонгон шалгаруулалтыг ил тод, нээлттэй өрсөлдөх боломжоор хангаж ажилласан байна.

Салбарын яамдаас 2018 онд тус аймгийн Засаг даргад эрх шилжүүлсний дагуу улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих барилга угсралтын 8 ажил, засварын 7 ажил, зам гүүрийн 3 ажил, авто машин бэлтгэх 1 ажил, зураг төсвийн 2 ажил зэрэг бүгд 21 ажлын гүйцэтгэгчийг Орон нутгийн өмчийн газраас сонгон шалгаруулсан байна.

2018 онд эрх шилжсэн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл арга хэмжээнээс Сагсай сумын Хүүхдийн цэцэрлэгийн барилга, Дэлүүн сумын 1 дүгээр сургуулийн дотуур байрны барилга, Өлгий сумын Бага сургууль, цэцэрлэгийн цогцолборын барилга, Буянт сумын Халуун усны барилга, Өлгий сумын үерийн хамгаалалтын далан сувгийн барилга, Аймгийн Орон нутгийн судлах музейн засвар, 1000, 900 айлын орон сууцны хороолол ус дамжуулах төвийн гадна инженерийн шугам сүлжээний ажил, Алтай сумын услалтын систем барих 8 ажлын тендерийн үнэлгээтэй холбоотой оролцогчдоос Сангийн яаманд гомдол гаргасан байна.

Дээрх маргааныг Сангийн яамнаас хянаж үзээд Дэлүүн сумын 1 дүгээр сургуулийн дотуур байрны барилга болон Өлгий сумын үерийн хамгаалалтын далан сувгийн барилгын ажил зэрэг 2 ажлыг үнэлгээний хорооны шийдвэрээр ажлыг үргэлжлүүлэхээр шийдвэрлэжээ.

Харин Буянт сумын Халуун усны барилга, 1000, 900 айлын орон сууцны хороолол ус дамжуулах төвийн гадна инженерийн шугам сүлжээний ажил, Алтай сумын услалтын систем барих ажил зэрэг 3 ажлын тендер шалгаруулалтын



үнэлгээг дахин хийхээр ирүүлсэн зөвлөмжийн дагуу Үнэлгээний хороо дахин үнэлж үзэхэд үнэлгээний хорооны анхны шийдвэр үндэслэлтэй гарсан байна.

Өлгий сумын Бага сургууль, цэцэрлэгийн цогцолборын барилга, Сагсай сумын Хүүхдийн цэцэрлэгийн барилга, Аймгийн Орон нутгийн судлах музейн засварын ажлуудын тендер шалгаруулалтын үнэлгээг дахин үнэлж үзэхэд үнэлгээний хорооны анхны шийдвэр үндэслэлгүй болох нь тогтоогдож хүчингүй болгосон байна.

Алтай сумын услалтын систем барих ажил, Сагсай сумын Хүүхдийн цэцэрлэгийн барилга барих ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлын үнэлгээтэй холбоотой гарсан зөрчил нь хуулийн байгууллагаар хянагдаж маргалдагч талууд нэхэмжлэлээ татаж авснаар дээрх маргаанууд эцэслэгдэн шийдвэрлэгдсэн байна.

Дээрх байдлаас үзэхэд гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах явцад тендерийн үнэлгээтэй холбоотой үндэслэлтэй маргаан гарч байгаа явдалд дүгнэлт хийж, цаашид тендер шалгаруулах ажлыг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг Орон нутгийн өмчийн газарт зөвлөмж болгов.

Тус аймгийн Орон нутгийн өмчийн газар нь 2018 онд бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааг цахим хэлбэрээр зохион байгуулж, худалдан авах бараа, ажил үйлчилгээний товч тодорхойлолт, тендерийн бичиг баримт, тендерт оролцогчдын ирүүлсэн тендер зэргийг цахим болон цаасан хэлбэрээр төсөл арга хэмжээ бүрээр архивын нэгж болгон хадгалжээ.

Харин ЭМЯамны сайдын эрх шилжүүлснээр аймгийн Эрүүл мэндийн газраас “Аймгийн Нэгдсэн эмнэлгийн наркологийн тасгийн засварын ажил”-ын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулжээ.

Шалгаруулсан тендерүүдэд нийтдээ 38 аж ахуйн нэгж материал ирүүлсэн ба зарласан ажлын тоонд харьцуулж үзэхэд нэг тендерт ойролцоогоор 2 аж ахуйн нэгж материал ирүүлсэн тооцоо гарч байна.

**Б.1.5. ТЕЗ худалдан авах ажиллагааны тайланг хугацаанд нь тайлагнасан байна.**

Худалдан авах ажиллагааны тайлан мэдээг улирал бүр Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааг мэдээлэх, тайлагнах журмын 1, 2 дугаар хүснэгт маягтын дагуу гаргаж аймгийн Засаг даргаар батлуулан, улирал бүр Санхүү төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлсэн байна.

Сангийн яамнаас тус аймгийн Худалдан авах ажиллагааны 2018 оны хэрэгжилтэд “маш сайн” гэсэн үнэлгээ өгсөн байна.

**Б.2. Зарим гүйцэтгэгч гэрээний үүргээ хугацаанд нь биелүүлээгүй байна.**

**Б.2.1 Зарим төсөл арга хэмжээ гэрээнд заасан хугацаандаа хэрэгжээгүй байна.**



2018 онд эрх шилжүүлэн хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээнүүдээс Сагсай сумын Хүүхдийн цэцэрлэгийн барилга, Өлгий сумын 4 дүгээр багийн айл өрхийн цэвэр усны шугам, Аймгийн БСУГазрын конторын засвар, аймгийн ХДТеатрын байрны засвар, МСҮТөвийн дотуур байрны засвар, Өлгий сумын 5 дугаар сургуулийн спорт заалны засвар, Толбо сумын Зуслангийн авто зам, давааны засварын ажил, Толбо сумын Нарийн голын модон гүүр, Хойд голын модон гүүр барих ажил, Алтай сумын услалтын систем барих ажил, Баяннуур сумын ногооны зоорь барих ажил болон аймгийн ЗДТГазарт автомашин, ХДТеатрын хөгжмийн зэмсэг нийлүүлэх ажил зэрэг бүгд 13 ажлыг тухайн жилд бүрэн хийж дуусган захиалагч байгууллагад актын дагуу ашиглалтад хүлээлгэн өгчээ.

Аймгийн төвийн гудамжны гэрэлтүүлэг, цахилгаан шугам сүлжээний зураг төсөв, Төрийн үйлчилгээний нэгдсэн цогцолборын зураг төсөв зэрэг 2 зураг төсвийн ажлыг гүйцэтгэгч компаниас захиалагчид хүлээлгэн өгсөн байна.

Он дамжин хэрэгжих Өлгий сумын Бага сургууль, цэцэрлэгийн цогцолборын барилга, Өлгий сумын үерийн хамгаалалтын далан сувгийн барилга зэрэг ажлууд 6-11,3 хувийн хэрэгжилттэйгээр дараа онд шилжсэн байна.

Харин 1000, 900 айлын орон сууцны хороолол ус дамжуулах төвийн гадна инженерийн шугам сүлжээний ажил нь хүйтний улирал болсон учир ажил эхлээгүй, санхүүжилтийг яамд төвлөрүүлсэн байна.

Захиалагч, гүйцэтгэгч нарын хооронд хийсэн гэрээний хэрэгжилтийг авч үзэхэд 2018 онд эрх шилжсэн улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих бүгд 22 төсөл арга хэмжээнээс 19 төсөл арга хэмжээ бүрэн хэрэгжиж дуусахаар гэрээ хийгдсэнээс 15 ажил гэрээнд заасан хугацаанд бүрэн хэрэгжиж, 4 төсөл арга хэмжээ гэрээнд заасан хугацаандаа хэрэгжээгүй байна.

Тухайлбал: Дэлүүн сумын 1 дүгээр сургуулийн дотуур байрны барилгын ажлын гүйцэтгэгч “Ганбарс” ХХКомпани, Буянт сумын Халуун усны барилгын ажлын гүйцэтгэгч “Монстрой Эра” ХХК, Нэгдсэн эмнэлгийн сэтгэц наркологийн тасгийн засварын ажлын гүйцэтгэгч “Көркем” ХХК, Аймгийн Орон нутгийн судлах музейн засварын ажлын гүйцэтгэгч “Мурап” ХХКомпаниуд гэрээлсэн ажлуудаа гэрээнд заасан хугацаандаа хийж дуусгаагүй, гэрээний үүргээ биелүүлээгүй байна.

Гэрээ хийсэн хугацааг авч үзвэл “Ганбарс” ХХКомпани 7 дугаар сарын 10-аас 12 дугаар сарын 20-ны хооронд, “Монстрой Эра” ХХКомпани 10 дугаар сарын 4-нөөс 12 дугаар сарын 10-ны хооронд, “Көркем” ХХКомпани 7 дугаар сарын 10-аас 8 дугаар сарын 30-ны хооронд, “Мурап” ХХКомпани 11 дүгээр сарын 19-ээс 12 дугаар сарын 25-ны хооронд хийж дуусгаахаар тус тус гэрээ хийжээ.

Эдгээр ажлуудын гэрээнд заасан хугацаандаа дуусаагүй байгаа шалтгааныг судалж үзэхэд Дэлүүн сумын 1 дүгээр сургуулийн дотуур байрны барилга, Буянт сумын Халуун усны барилга, Аймгийн Орон нутгийн судлах музейн засварын ажлууд худалдан авах ажиллагааны маргаантай холбоотойгоор ажил нь оройтож эхэлсэнтэй холбоотой гэж үзэх үндэстэй байна.

Нэгдсэн эмнэлгийн сэтгэц, наркологийн тасгийн засварын ажлын хувьд гүйцэтгэгч ямар ч шалтгаангүйгээр төсөл арга хэмжээг гэрээнд заасан



хугацаандаа багтаан хэрэгжүүлээгүй, гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй байна.

Аудитын дүнгээр гэрээнд заасан хугацаанд хэрэгжээгүй 1447,5 сая төгрөгийн өртөг бүхий 4 төсөл арга хэмжээг зөрчилд тооцож, гүйцэтгэгч компаниудын гэрээнд заасан үүргийг биелүүлэх, захиалагчийн зүгээс тавих хяналтыг сайжруулах, хөрөнгө оруулалтын үр ашгийг дээшлүүлэх талаар холбогдох албан тушаалтнуудад албан шаардлагаар үүрэг өгөв.

Гүйцэтгэгч байгууллагуудын ажлын гүйцэтгэл, ажлын явцад мэргэжлийн байгууллагуудаас хийсэн хяналтын дүгнэлт, материалтай танилцаж үзэхэд тухайн жилд гүйцэтгэгч компаниудад ажиллах хүч, техник хэрэгсэл, машин механизмын хүрэлцээгүйгээс болж ажил саатсан тохиолдол гараагүй байна.

*Б.2.2. Захиалагч зохиогч, мэргэжлийн байгууллагын хяналтаар илэрсэн зөрчлийг тухай бүрд нь арилгах арга хэмжээг авч ажилласан байна.*

Хэрэгжсэн төсөл арга хэмжээнүүдийн хэрэгжилтэд захиалагчийг төлөөлж үе шатны ажлын гүйцэтгэлд ЗДТГазрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн, Барилга захиалагчийн албаны дарга, инженерүүд газар дээр нь хяналт тавьж, зураг төсвийн дагуу хийгдэж байгаа эсэхэд хяналт тавьж, илэрсэн зөрчил дутагдлыг тухай бүр арилгуулсан байна.

Захиалагч байгууллагын хяналтаар Өлгий сумын үерийн хамгаалалтын далан сувгийн барилгын ажлыг гүйцэтгэх явцад гарсан нөхцөл байдалтай холбоотойгоор далангийн сувгийн ёроолд чулуу дэвсэх, далангийн орчим авто машин болон явган хүний гүүрэн гарцыг нэмж тавих зэргээр зураг төсөвт өөрчлөлт оруулах талаар зохиогчид даалгавар өгч, зураг төсөвт өөрчлөлт оруулсан байна.

Буянт сумын халуун усны улаан шугамыг зохиогчид хүсэлт тавьж өөрчлүүлэхээр, Сагсай сумын Хүүхдийн цэцэрлэгийн ханын дүүргэвчийг зурагт төсөвт зааснаас өөр материалаар хийж байсныг зохиогчоор тооцоо хийлгэн зөвшөөрөл авч, зураг төсөвт өөрчлөлт оруулсан байна.

Дэлүүн сумын сургуулийн дотуур байрны барилгын бохирын цооногийн зураг төсөвт заасан байршлыг зохиогчид хүсэлт тавьж, өөрчлүүлсэн байна.

Дээрх илэрсэн зөрчлүүдийг зураг төсөвт өөрчлөлт оруулснаар арилгуулж, барилгын ажлыг гүйцэтгэх явцад технологийн горим зөрчигдсөн, барилгын ажлын эхлэх, дуусах хугацаа зөрчигдсөн асуудлуудыг тухай бүр хяналтын журналд тэмдэглэж арилгуулах арга хэмжээ ажилласан байна.

Зохиогчоос тавьсан хяналтаар зураг төсөв зөрчигдсөн зөрчил гараагүй байна.

*Б.2.3. Гүйцэтгэгч төсөл, арга хэмжээний санхүүжилтийг зориулалтын дагуу зарцуулсан байна.*

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2018 онд санхүүжилтийн эрх шилжиж ирсэн 14 төсөл арга хэмжээнд нийтдээ 3396.2 сая төгрөгийн санхүүжилт олгогдсоноос гүйцэтгэгч компаниудад ажлын гүйцэтгэлээр 3326.9 сая төгрөгийг, хяналтын зардалд 40.0 сая төгрөгийг, зураг төсвийн үнэнд 29.3 сая төгрөгийг,



геологийн зардалд 5.2 сая төгрөгийг тус тус холбогдох баримтыг үндэслэн тус тусын харилцах данснаас шилжүүлсэн байна.

Төсөл, арга хэмжээний санхүүжилтийг Сангийн сайдын 2016 оны 415 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналтын журам”-ын 14.4-д заасны дагуу гүйцэтгэгчийн ажлын гүйцэтгэлийг үндэслэн захиалагчийн хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан эрх олгосон албан тушаалтнаас хянасны дараа “Хяналтын хүснэгт”-ийг бөглөж, Сангийн яаманд хүргүүлж журамд заасан хугацаанд санхүүжилтийг олгосон байна.

- БСШУСайдын эрх шилжсэн хөрөнгө оруулалтын Төрийн сан дахь харилцах данснаас 2018 онд эрх шилжсэний дагуу 2481.5 сая төгрөгийн санхүүжилтийг дараах төсөл арга хэмжээний гүйцэтгэгчид ажлын гүйцэтгэлээр олгожээ.

Үүнд: Аймгийн БСУГазрын сургалтын танхимын цонх, хаалга солих засварын ажлын гүйцэтгэгч “Наз-Алем” ХХК-д 9.7 сая төгрөгийн, Аймгийн ХДТеатрын байрны засвар ажлын гүйцэтгэгч “Досстрой” ХХК-д 34,1 сая төгрөгийн, ХДТеатрын хөгжмийн зэмсэг худалдан авах ажлын “Аяана” ХХК-д 34.7 сая төгрөгийн, Дэлүүн сумын сургуулийн дотуур байрны барилгын гүйцэтгэгч “Ганбарс” ХХК-д 936,9 сая төгрөгийн, Сагсай сумын Хүүхдийн цэцэрлэгийн барилгын гүйцэтгэгч “Чандмань Уушир” ХХК-д 1081.0 сая төгрөгийг, Өлгий сумын 5 дугаар сургуулийн Спорт заалны засварын ажлын гүйцэтгэгч “Жайых” ХХК-д 62.7 сая төгрөгийн, Өлгий сумын Бага сургууль, цэцэрлэгийн цогцолборын барилгын гүйцэтгэгч “Агайын” ХХК-д 186.1 сая төгрөгийн, аймгийн Орон нутгийн судлах музей засварлах ажлын гүйцэтгэгч “Мурап” ХХК-д 142.5 сая төгрөгийн санхүүжилтийг тус тус олгожээ.

- ЭМСайдын эрх шилжсэн хөрөнгө оруулалтын данснаас 2018 онд шинээр хэрэгжсэн Нэгдсэн эмнэлгийн сэтгэц наркологийн тасгийн засварын ажлын санхүүжилтэд “Көркем” ХХК-д 49,0 сая төгрөг олгосон байна. Тус засварын ажил гэрээний дагуу хийгдээгүй, ашиглалтын комисс хүлээж аваагүйгээс санхүүжилтийг гүйцэтгэгчид хугацаандаа бүрэн олгогдоогүй байна.
- ХНХСайдын эрх шилжсэн хөрөнгө оруулалтын данснаас 2018 онд шинээр хэрэгжсэн Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн дотуур байрны засварын ажлын санхүүжилтэд “Ёлт констракшн” ХХК-д 69.3 сая төгрөгийг ажлын гүйцэтгэлээр олгосон байна.
- БХБСайдын эрх шилжсэн хөрөнгө оруулалтын Төрийн сан дахь харилцах данснаас 2018 онд эрх шилжсэний дагуу 694,5 сая төгрөгийн санхүүжилтийг дараах төсөл арга хэмжээний гүйцэтгэгчид ажлын гүйцэтгэлээр олгожээ.

Аймгийн төвийн гэр хорооллын цэвэр усны шугамыг дулаалах болон зарим айл, өрхийг цэвэр усны шугам сүлжээнд холбох /Өлгий сумын 4-р багийн айл өрхүүдийг цэвэр усны шугамд холбох ажлын санхүүжилтэд “Суат” ХХК-д 100.0 сая төгрөгийн, Үерийн усны хамгаалалтын далан сувгийн эхний ээлжийн ажил /16км/-ын санхүүжилтэд “Агайын” ХХК-д 491.7 сая төгрөгийн, Буянт сумын “Халуун усны барилгын ажил”-ын санхүүжилтэд “Монстрой Эра” ХХК-д 102.8 сая төгрөгийн санхүүжилтийг ажлын гүйцэтгэлээр тус тус олгосон байна.



- 2018 онд эрх шилжиж ирсэн төсөл арга хэмжээний санхүүжилтээс ГХБХБГазраас хяналт хийсэн 9 төсөл арга хэмжээний хяналтын зардалд 36.5 сая төгрөгийн, Барилга захиалагчийн албанд 2 төсөл арга хэмжээний хяналтын зардалд 3.4 сая төгрөгийн, зохиогч зураг төсөвчинд 7 ажлын 29.3 сая төгрөгийн, геологийн 1 ажлын зардлын 5.2 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Аймгийн төвийн гэр хорооллын цэвэр усны шугамыг дулаалах болон зарим айл, өрхийг цэвэр усны шугам сүлжээнд холбох ажлын санхүүжилтийн үлдэгдэл 76.4 сая төгрөгийг БХБЯамны хөрөнгө оруулалтын данснаас гүйцэтгэгч “Суат” ХХК-д шууд олгосон байна.

Захиалагч эрх шилжсэн хөрөнгө оруулалтын данснаас ажил гүйцэтгэгч компаниудын ажлын санхүүжилт, техник хяналтын зардал, зураг төсвийн үнэнд тус тус шилжүүлж санхүүжилтийг зориулалтын дагуу зарцуулжээ.

Гүйцэтгэгч байгууллагууд ТАХ-ний санхүүжилтийг зориулалт бусаар зарцуулсан асуудал гараагүй байна.

### ***Б.3. Захиалагч зарим төсөл арга хэмжээний гэрээний хэрэгжилтэд тавих хяналтаа хангалтгүй хэрэгжүүлсэн байна.***

*Б.3.1. Төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд захиалагчийн тавих үе шатны хяналтыг барилгын үе шат бүрээр хяналт тавьж баталгаажуулсан байна.*

2018 онд хэрэгжсэн төсөл арга хэмжээнүүдээс Барилгын хөгжлийн төв 1 төсөл арга хэмжээнд, Барилгын захиалагчийн алба 4 төсөл арга хэмжээнд, ГХБХБГазар 12 төсөл арга хэмжээнд тус тус хяналт тавьж ажилласан байна.

Сангийн сайдын 2016 оны 415 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналтын журам”-ын 4.1-д заасны дагуу хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний гүйцэтгэл, худалдан авах тоног төхөөрөмжийн актад захиалагчийг төлөөлж гарын үсэг зурах эрх бүхий барилгын хяналтын болон санхүү, хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан холбогдох албан тушаалтнуудыг томилж, томилсон тухай шийдвэрийг Сангийн яаманд хүргүүлсэн байна.

Төсөл арга хэмжээний хэрэгжилтэд захиалагчийг төлөөлж үе шатны ажлын гүйцэтгэлд ЗДТГазрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга, Барилга захиалагчийн албаны дарга, инженерүүд ажлын явц, чанар, хөдөлмөрийн аюулгүй байдалд газар дээр нь хяналт тавьж талбайн журналд тэмдэглэл үйлдэж, анхаарах асуудалд тухай бүр заавар, зөвлөгөө өгч дараагийн хяналтаар биелэлтийг шалгаж ажилласан байна.

Барилга угсралтын ажлын хувьд ажлын үе шат бүр дээр аймгийн төвд өдөр бүр, хөдөө сумд хийгдэж байгаа ажлын хувьд чухал хийц, шат шатны ажлын үеэр газар дээр нь хяналт тавьж, шинээр барьж байгаа барилга байгууламжийн далд ажлын явцад байнгын хяналт тавьж, ажлын үе шатаар нь фото зургаар баримтжуулж, акт үйлдэн талбайн ажлын журналд тэмдэглэгээ хийж баримтжуулсан байна.



Тухайн төсөл арга хэмжээний гүйцэтгэгч компани гаргасан үе шатны ажлын гүйцэтгэлийг Барилга захиалагчийн албаны хяналтын инженерүүд газар дээр нь хяналт тавьж, гарын үсэг зурж баталгаажуулсан байна.

Барилгын засварын ажил тус бүрт дунджаар 3-4 удаа газар дээр нь хяналт тавьж, зураг төсөвт тусгасан ажил, төсөвт тусгасан материалын төрөл, марктай тулган хяналтаа тавьж фотожуулан баримтжуулдаг байна.

*Б.3.2. Төсөл арга хэмжээний санхүүжилтийг бодит гүйцэтгэлд үндэслэн журамд заасан хугацаанд олгосон байна.*

Төсөл арга хэмжээний санхүүжилтийн хуваарийг гаргаж батлуулан, хуваарийг Сангийн яаманд хүргүүлсэн байна.

Төсөл, арга хэмжээний санхүүжилтийг Сангийн сайдын 2016 оны 415 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналтын журам”-ын 14.4-д заасны дагуу гүйцэтгэгчийн ажлын гүйцэтгэлийг үндэслэн захиалагчийн хөрөнгө оруулалтын асуудал хариуцсан эрх олгосон албан тушаалтнаас хянасны дараа “Хяналтын хүснэгт”-ийг бөглөж, Сангийн яаманд хүргүүлж журамд заасан хугацаанд санхүүжилтийг олгосон байна.

Аймгийн Төрийн сангаас ажлын гүйцэтгэл, “Хяналтын хүснэгт”, ажил гүйцэтгэгчийн нэхэмжлэл зэрэг зохих баримтуудыг үндэслэн урьдчилгаа болон эцсийн санхүүжилтийг тухай бүр журамд заасан хугацаандаа саадгүйгээр олгож ирсэн байна.

Оны эцэст Засгийн газрын 2018 оны 386 дугаар тогтоолыг үндэслэн Дэлүүн сумын сургуулийн дотуур байрны барилгын гүйцэтгэгч “Ганбарс” ХХК-д 61.6 сая төгрөгийн, Өлгий сумын Бага сургууль, цэцэрлэгийн цогцолборын барилгын гүйцэтгэгч “Агайын” ХХК-д 1788.4 сая төгрөгийн, аймгийн Орон нутгийн судлах музей засварлах ажлын гүйцэтгэгч “Мурап” ХХК-д 16.7 сая төгрөгийн, Буянт сумын Халуун усны барилгын ажлын санхүүжилтэд “Монстрой Эра” ХХК-д 105,4 сая төгрөгийн, нийтдээ 4 төсөл арга хэмжээний үлдэгдэл санхүүжилт 1972.1 сая төгрөгийг арилжааны банкнаас гаргасан баталгааны дагуу дээрх компаниудын арилжааны банкин дахь дансанд шилжүүлэн байршуулсан байна.

*Б.3.3. Хөрөнгө оруулалтын хэрэгжилтийн тайланг хугацаанд хүргүүлсэн байна.*

Сангийн сайдын 2016 оны 415 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналтын журам”-ын 6.3-д заасны дагуу эрх шилжсэн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний гүйцэтгэл, санхүүжилтийн мэдээ, ажлын явц, үр дүнгийн талаарх тайланг тухайн орон нутгийн байгууллага сар бүр зохих маягтаар дараа сарын 03-ны дотор Санхүү төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлсэн байна.

Тухайн жилийн хөрөнгө оруулалтын ажлын гүйцэтгэл, санхүүжилтийн мэдээг 2018 оны 5 дугаар сараас эхлэн сар бүр өгч ажилласан байна.

*Б.3.4. Гэрээний үүргээ биелүүлээгүй гүйцэтгэгчид хариуцлага тооцоогүй байна.*



2018 онд эрх шилжсэн 4 төсөл арга хэмжээг гэрээний хугацаандаа дуусгаагүй ба гэрээний үүргээ биелүүлээгүй эдгээр компаниудтай хариуцлага тооцоогүй боловч дутуу ажлуудаа гүйцээх талаар албан даалгавар өгч ажилласан байна.

Аудитын дүнгээр зарим төсөл арга хэмжээ гэрээнд заасан хугацаандаа багтаан хэрэгжихгүй байгаад дүгнэлт хийж, захиалагчийн зүгээс гүйцэтгэгч компаниудад гэрээний дагуу тавих хяналтыг сайжруулж ажиллахыг албан шаардлагад тусгасан болно.

#### **Б.4. Хөрөнгө оруулалтын үйл явцад тавих Засгийн газрын болон ТЕЗ-дын дотоод хяналт үр нөлөөтэй байна.**

*Б.4.1. Санхүү төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас тавих хяналт үр дүнтэй байна.*

Сангийн сайдын 2016 оны 415 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналтын журам”-ын 4.4-д заасны дагуу захиалагчийн санхүүжилт хүссэн материалыг хөрөнгө оруулалт хариуцсан мэргэжилтэн хянан баталгаажуулсны дараа албан тоот, “Хяналтын хүснэгт”-ийг бөглүүлж холбогдох материалын хамт Сангийн Яамд хүргүүлж хянуулсны дараа ажлын санхүүжилтийг олгож ирсэн байна.

Ажлын явцын санхүүжилтийг ажлын гүйцэтгэлээр, эцсийн санхүүжилтийг төсөл арга хэмжээг ашиглалтад хүлээж авсан акт гарсны дараа олгосон байна. Зураг төсвийн үнэ, захиалагчийн хяналтын зардал, чанарын баталгаат хугацааны барьцааг холбогдох материалыг үндэслэн шилжүүлжээ.

*Б.4.2. Хөрөнгө оруулалтын хэрэгжилтэд тавих ТЕЗ-ийн дотоод хяналтыг зохих түвшинд тавьж ажилласан байна.*

Эрх шилжсэн хөрөнгө оруулалтын ажлуудад ТЕЗ-дын зүгээс тавих дотоод хяналтыг аймгийн ЗДТГазрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсээс хэрэгжүүлж, төсөл арга хэмжээний явц болон гүйцэтгэлийг хянах, санхүүжилтийг олгоход журамд зааснаар ажлын гүйцэтгэлийг үндэслэн “Хяналтын хүснэгт”-ийг бөглөх, хэрэгжсэн төсөл арга хэмжээг хүлээж авах зэрэг ажлын бүх үе шатанд хяналт тавьж ажилласан байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчаас төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа төсөл арга хэмжээний гүйцэтгэл, барилгын чанарт тавих мэргэжлийн байгууллагын хяналтыг ГХБХБГазар болон Барилга захиалагчийн албаар дамжуулан хэрэгжүүлж ажилласан байна.

Аймгийн Засаг даргын 2018 оны 9 дүгээр сарын 7-ны өдрийн А/664 тоот захирамжийн дагуу байгуулсан ажлын хэсгээс бүх сум орон нутагт хэрэгжиж байгаа хөрөнгө оруулалтын ажлын хэрэгжилт, явц, барилгын ажилтай холбоотой зөвшөөрөлтэй эсэх, үе шатны хяналт тавьсан эсэхийг газар дээр нь шалгаж, хэрэгжилтийг Засаг даргын зөвлөлийн хурлаар авч хэлэлцэж, ЗДТГазрын хяналт шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын хэлтсээс хөрөнгө оруулалтын ажил хэрэгжих шатандаа буюу 70 хувийн хэрэгжилттэй хэвийн явагдаж байна гэж дүгнэсэн байна.



## ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлт хийж байна. Үүнд:

### **Бүлэг 2. *Зарим төсөл арга хэмжээ гэрээнд заасан хугацаандаа хэрэгжээгүй байна.***

#### ***Б.1. Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажиллагаа холбогдох хууль журмын дагуу зохион байгуулагдсан байна.***

- Б.1.1. Эрх шилжүүлэн хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээг хэрэгжүүлэх боломжтой хугацаанд шилжүүлжээ.
- Б.1.2. 8 төсөл арга хэмжээний үнэлгээний хорооны шийдвэртэй холбоотой маргаан гарсан байна.
- Б.1.3. Тендерийн баримт бичгийг хууль журмын дагуу боловсруулсан байна.
- Б.1.4. Сонгон шалгаруулалтыг ил тод, нээлттэй өрсөлдөх боломжоор хангаж зохион байгуулсан байна.
- Б.1.5. ТЭЗ худалдан авах ажиллагааны тайланг хугацаанд нь тайлагнасан байна.

#### ***Б.2. Зарим гүйцэтгэгч гэрээний үүргээ хугацаанд нь биелүүлээгүй байна.***

- Б.2.1 Зарим төсөл арга хэмжээ гэрээнд заасан хугацаандаа багтаан хэрэгжээгүй байна.
- Б.2.2. Захиалагч, зохиогч, мэргэжлийн байгууллагын хяналтаар илэрсэн зөрчлийг тухай бүрд нь арилгах арга хэмжээг авч ажилласан байна.
- Б.2.3. Гүйцэтгэгч төсөл, арга хэмжээний санхүүжилтийг зориулалтын дагуу зарцуулсан байна.

#### ***Б.3. Захиалагч зарим төсөл арга хэмжээний гэрээний хэрэгжилтэд тавих хяналтаа хангалтгүй хэрэгжүүлсэн байна.***

- Б.3.1. Төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд захиалагчийн тавих үе шатны хяналтыг барилгын үе шат бүрээр тавьж байжээ.
- Б.3.2. Бүрэн хэрэгжээгүй төсөл арга хэмжээний санхүүжилтийг баталгаа гаргуулан арилжааны банкинд байршуулжээ.
- Б.3.3. Хөрөнгө оруулалтын хэрэгжилтийн тайланг хугацаанд хүргүүлсэн байна.
- Б.3.4. Гэрээний үүргээ биелүүлээгүй гүйцэтгэгчид хариуцлага тооцоогүй байна.

#### ***Б.4. Хөрөнгө оруулалтын үйл явцад тавих Засгийн газрын болон ТЭЗ-дын дотоод хяналт үр нөлөөтэй байна.***

- Б.4.1. Санхүү төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас тавих хяналт үр дүнтэй байна.
- Б.4.2. Хөрөнгө оруулалтын хэрэгжилтэд дотоодын хяналтыг зохих түвшиндээ тавьж ажилласан байна.



## Бүлэг 3


Улсын төсвийн хөрөнгө оруулалтын тухайн жилд хүрэх зорилтот түвшин 82 хувьтай байна.

**В.1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын тухайн жилд хүрэх зорилтот түвшин 82 хувьтай байна.**

*В.3.1. 2018 онд ашиглалтад орсон төсөл, арга хэмжээ бүрэн хүчин чадлаар ашиглагдаж байна.*

Аудитын явцад 2018 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн төсөл арга хэмжээний хэрэгжилтийг 14 сумаар явж үзэхэд эрх шилжсэн хөрөнгө оруулалтаар Өлгий, Алтай, Буянт, Баяннуур, Дэлүүн, Толбо, Сагсай зэрэг 7 сумд нийтдээ 19 төсөл арга хэмжээ хэрэгжихээс, 6 төсөл арга хэмжээ 6-89 хувийн гүйцэтгэлтэйгээр 2019 онд шилжиж, 13 ажил бүрэн хэрэгжсэн байна.

Сагсай сумын Хүүхдийн цэцэрлэгийн барилга, Өлгий сумын 4 дүгээр багийн айл өрхийн цэвэр усны шугам, аймгийн БСУГазрын конторын засвар, аймгийн ХДТеатрын байрны засвар, МСҮТөвийн дотуур байрны засвар, Өлгий сумын 5 дугаар сургуулийн спорт заалны засвар, Толбо сумын Зуслангийн авто зам, давааны засварын ажил, Толбо сумын Нарийн голын модон гүүр, Хойд голын модон гүүр барих ажил, Баяннуур сумын ногооны зоорь барих ажил болон аймгийн ЗДТГазарт автомашин, ХДТеатрын хөгжмийн зэмсэг нийлүүлэх зэрэг ажлууд бүрэн хэрэгжиж, ашиглалтад хүлээж авсан байна.



**Сагсай сумын Хүүхдийн цэцэрлэгийн барилга**



***Аймгийн Хөгжимт драмын театрын засварын ажил***



***Баяннуур сумын Ногооны зоорийн барилга***



*Алтай сумын Услалтын систем*



*Толбо сумын Хойд, Нарийн голын модон гүүр*



*Толбо сумын Зуслангийн давааны засвар*



### ***Аймгийн Хөгжимт драмын театрын хөгжмийн зэмсэг***

Дээрх ажлуудын хэрэгжилтийн байдлыг газар дээр нь очиж шалгаж үзэхэд хөрөнгө оруулалтын ажлыг бүрэн хүчин чадлаараа ашиглаж, хүрэх зорилтот түвшиндээ хүрч байгаа ба ашиглагч байгууллагууд хөрөнгө оруулалтын ажлын гүйцэтгэлд сэтгэл ханамжтай байгаа талаар саналаа хэлж байлаа.

Алтай сумын услалтын систем барих ажлын зураг төсөвт тусгагдсан ажлууд бүрэн хийгдэж ашиглалтад хүлээлгэж өгсөн ба дулааны улирал эхлэхээр ус шахах насосыг ажиллуулж, зүгшрүүлэх ажлуудыг хийхээр гэрээлэгч, захиалагчид хоорондоо тохиролцож акт үйлдсэн байна.

2018 онд дутуу хэрэгжсэн Дэлүүн сумын сургуулийн дотуур байрны барилга, Буянт сумын Халуун усны барилга, аймгийн Орон нутгийн судлах музейн засвар, Нэгдсэн эмнэлгийн сэтгэц наркологийн тасгийн засварын ажил зэрэг 4 төсөл арга хэмжээний ажил гүйцэтгэсэн байдлыг газар дээр нь очиж шалгаж үзэхэд дараах байдалтай байна. Үүнд:

Дэлүүн сумын сургуулийн дотуур байрны барилгын ажил бүрэн дууссан байдалтай байгаа ба ГХБХБГазраас албан даалгавар өгч зарим дутуу ажлуудыг нөхөж хийлгэн ашиглалтад өгөхөөр болсон байна. Тус ажлын анхны гэрээг 2019 оны 1 дүгээр сарын 30-нд дуусгахаар сунгасан боловч одоогоор ашиглалтад бүрэн хүлээлгэж өгөөгүй байна.

Орон нутгийн судлах музейн дотор талын засварын ажлыг зураг төсвийн дагуу хийсэн ба гадна талын засварын ажлыг 2019 оны 2 дугаар сарын 5-ны дотор хийж дуусгахаар гэрээг сунгасан боловч ажил хараахан эхлээгүй байна.

Ашиглагч байгууллагын удирдлага нь засварын ажил зураг төсвийн дагуу сайн хийгдсэн, хүйтний улирал эхэлсэн учир гадна талын ажлыг түр зогсоосон, 4 дүгээр сард дуусгахаар болж байгаа засварын ажил зохих үр дүнгээ өгч байна гэж саналаа хэлж байв.



Буянт сумын Халуун усны барилгын ажил гүйцэтгэлээр 50 хувьтай гарсан ба хана өрөгдсөн байдалтай, гадна талаас нь харахад барилгын суурь цутгагдаагүй мэт харагдаж байна.

Ажил гүйцэтгэгч “Монстрой Эра” компаний ажлын үе шатны гүйцэтгэлийн фотожуулсан зургийг үзэхэд ханыг суурьтай хамт хөөсөн хавтангаар хучиж гадна талыг нь туйпуугаар бүрсэн байна. Ашиглагч байгууллагын саналын дагуу зарим ажлуудыг нэмж хийхээр болсон, ажлыг чанартай хийж гүйцэтгэнэ, худалдан авалтын маргаантай холбоотой гэрээний хугацаанд хийж амжаагүй гэсэн тайлбар өгч байв.

Нэгдсэн эмнэлгийн сэтгэц наркологиын тасгийн засварын ажлыг газар дээр нь үзэхэд зураг төсвийн дагуу хана эмульсээр будсан, дүүжин тааз хийсэн, 00-ын өрөөний плита тавьсан, зарим өрөөний хаалга, цонхыг сольж бэхэлгээ хийсэн, коридорын шалыг паркетлэх зэрэг ажлууд хийгдсэн байна. Хийгдсэн ажлуудыг зурагжуулж авахад зарим хананд тавьсан замаск нь ховхорсон, угаалгын өрөөний ханын плита нь унасан, цонхны бэхэлгээ суларсан, ханыг 2 өөр өнгөөр будсан, тасгийн үүдний хэсэгт засвар хийгдээгүй гэх мэт зөрчлүүд байна. Ашиглагч байгууллагын төлөөллүүд дээрх зөрчлүүдийг газар дээр нь үзүүлж гомдол хэлж байсан болно.

***Хугацаа хэтэрсэн төсөл арга хэмжээний зураг***



***Дэлүүн сумын сургуулийн дотуур байрны барилга /73 хувийн гүйцэтгэлтэй/***





**Аймгийн Орон нутгийг судлах музейн засвар /Гадна талын засвар дутуу/**



**Буянт сумын Халуун усны барилга /50 хувийн гүйцэтгэлтэй/**



**Нэгдсэн эмнэлгийн сэтгэц наркологийн тасгийн засвар**

2018 онд хэрэгжсэн төсөл арга хэмжээнүүдийг орлогод авсан эсэхийг шалгаж үзэхэд Дэлүүн сумын 1 дүгээр сургуулийн дотуур байрны барилга, Буянт сумын Халуун усны барилга, Баяннуур сумын ногооны зоорь, Алтай сумын услалтын систем зэрэг 4 төсөл арга хэмжээний 1307.8 сая төгрөгийн хөрөнгийг ашиглагч байгууллагууд дуусаагүй барилга байгууламжаар орлого авч данс бүртгэлд тусгаагүй байгааг зөрчилд тооцон албан шаардлага өгөв.

**В.2. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээнүүд зохих үр нөлөөгөө өгчээ.**

**В.2.1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн төсөл арга хэмжээ зохих үр нөлөөгөө өгсөн байна.**



Хөрөнгө оруулалтаас бий болох үр ашгийг арга хэмжээ тус бүрээр төлөвлөөгүй боловч хэрэгжсэн төсөл арга хэмжээнүүд зохих үр нөлөөгөө өгсөн байна.

ТЕЗ-даас эрх шилжүүлэн 2018 онд хэрэгжүүлсэн нийт төсөл арга хэмжээний 61,1 хувь нь боловсролын салбарт, 3,6 хувь нь хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарт, 12,9 хувь нь ХАА-н салбарт, 20,8 хувь нь дэд бүтцийн салбарт, үлдсэн 1,6 хувь нь бусад салбарт хэрэгжсэн байна.

Тухайн жилийн эрх шилжсэн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн төсөл арга хэмжээний дийлэнх нь боловсролын салбарт хэрэгжсэн ба эдгээр төсөл арга хэмжээний хүрээнд сургалтын орчинг сайжруулснаар хүүхдийн сурах боломжийг бүрдүүлсэн, сургуулийн өмнөх насны хүүхдийн цэцэрлэгт хамрагдалт өмнөх жилүүдээс нэмэгдсэн, сургалтын орчин сайжирсан, дотуур байрны хүүхдийн амьдрах орчинг сайжруулснаар хүүхдийн ая тухтай амьдрах, сурах боломж хангагдсан зэргээр боловсролын байгууллагын хэмжээнд зохих үр нөлөөгөө өгч байна.

Дэд бүтэц болон Хөдөө аж ахуйн салбарт хэрэгжсэн төсөл арга хэмжээнүүдийн хүрээнд хөдөөгийн багуудад шинээр зам, гүүр тавигдсан, газар тариалангийн талбайг усжуулах, ногоо хадгалах зоорь барих ажлууд хийгдсэнээр малчдын нүүдэл, суудал хийх боломжийг илүү бүрдүүлсэн, малын тэжээл бэлтгэх газар тариалан эрхлэх боломж бүрдсэн, газар тариалангийн бүтээгдэхүүнийг хадгалах боломжоор хангагдаж ард иргэдийг хүнсний ногоогоор тасралтгүй хангах боломжтой болсон зэрэг иргэдийн амьдралд бодит үр нөлөө үзүүлэхүйц арга хэмжээнүүд хэрэгжсэн гэж үзэх үндэстэй байна.

Хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээг аль болох шаардлагатай төсөл арга хэмжээнд төлөвлөж, хэрэгжүүлж байгаа боловч тайлант онд төлөвлөсөн 4 төсөл арга хэмжээ хэрэгжээгүй байгаа нь бодит үр дүн төлөвлөсөн хэмжээнд бүрэн хүрээгүй байна.

Аймгийн ИТХ-ын хуралдаанаар Аймгийн Засаг даргын 2018 оны үйл ажиллагааны тайланг хэлэлцүүлэхэд тухайн жилийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний биелэлт үр дүнг хавсралт тайлан болгон оруулж, хөрөнгө оруулалтын ажлын зорилт, үр дүн хангагдсан гэж дүгнэжээ.

*В.2.2. Хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний төсөвт өртгийг нэмэгдүүлсэн гэж үзэх үндэслэл байхгүй байна.*

2018 онд хэрэгжсэн барилга угсралт, засварын ажлуудын төсөвт өртгийг тусгай эрх бүхий барилгын мэргэшсэн төсөвчний баталгаа өгч гаргасан зураг төсвийн дагуу тогтоож байгаа учир ажлын төсөвт өртгийг үндэслэлгүй нэмэгдүүлсэн асуудал байхгүй байна.

*В.2.3. Өмнөх аудитаар өгсөн зөвлөмж өгөгдөөгүй байна.*

Улсын төсвийн эрх шилжсэн хөрөнгө оруулалтын 2017 оны хэрэгжилтэд хийсэн гүйцэтгэлийн аудитаар зөвлөмж өгөгдөөгүй байна.

Гүйцэтгэлийн аудитын дүнгээр эрх шилжсэн улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа 1307.8 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын ажлыг ашиглагч байгууллага орлогод авч данс бүртгэлд тусгаагүй, 1447,5 сая төгрөгийн өртөг бүхий 4 төсөл арга хэмжээ гэрээнд заасан хугацаанд хэрэгжээгүй зэргээр нийтдээ 2755,3 сая төгрөгийн зөрчил илэрсэнийг арилгуулахаар албан шаардлага өгөгдөв.



## ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлт хийж байна. Үүнд:

### **Бүлэг 3. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын тухайн жилд хүрэх зорилтот түвшин 82 хувьтай байна.**

#### **В.1. Улсын төсвийн хөрөнгө оруулалт тухайн жилд хүрэх зорилтот түвшинг хангаж ажилласан байна.**

В.3.1. 2018 онд ашиглалтад орсон төсөл, арга хэмжээ бүрэн хүчин чадлаар ашиглагдаж байна.

#### **В.2. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээнүүд зохих үр нөлөөгөө өгчээ.**

- В.2.1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн төсөл арга хэмжээ зохих үр нөлөөгөө өгсөн байна.
- В.2.2. Хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний төсөвт өртгийг үндэслэлгүй нэмэгдүүлсэн асуудал байхгүй байна.
- В.2.3. Өмнөх аудитаар зөвлөмж өгөгдөөгүй байна.



## **Зөвлөмж**

Аудитын дүнд үндэслэн дор дурдсан албан тушаалтнуудад дараах зөвлөмжийг өгч байна.

### **Аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга Т.Назым танаа**

1.Тендерийн маргаанаас болж хөрөнгө оруулалтын ажил хугацаандаа хэрэгжихгүй байгаа явдалд дүгнэлт хийж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажиллагаанд хууль, журмыг мөрдөж, тендерт оролцогч компаниудаар маргаан гаргахгүйн тулд үнэлгээний хорооны гишүүдийг мэргэжлийн арга зүйгээр ханган, ТБОНӨХБАҮХАТ хуулийн хэрэгжилтэд хяналт тавьж, төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын ажлыг хугацаанд нь гүйцэтгүүлэх боломж бүрдүүлэн ажиллах;



# Холбогдох байгууллагын санал

## Аймгийн Засаг даргаас ирүүлсэн санал:





**ТАЙЛАНГ ХЯНАЖ, БАТАЛГААЖУУЛСАН:**

ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

М. ХУАНГАН

**ТАЙЛАНГ ХЯНАСАН:**

АУДИТЫН МЕНЕЖЕР

Х.ЖЕНИСБЕК

**ТАЙЛАНГ БЭЛТГЭСЭН:**

АУДИТОР

Б.ҮҮРИЙНТУЯА

ГЭРЭЭТ АУДИТОР

К.РИЗА